



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 03 өдөр

Дугаар А/54.

Бат-Өлзий сум

Тамхи худалдах тусгай зөвшөөрөл
сунгах тухай


Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2, 7.3 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 16 дугаар зүйлийн 16.3.4, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бат-Өлзий сумын нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй Ж.Мөнхбат эзэнтэй "Алтан нутаг", Ж.Гансугар эзэнтэй "Хангайн овоо", М.Насанхүү эзэнтэй "Нар" хүнсний дэлгүүрүүдийн тамхи худалдах тусгай зөвшөөрлийн хугацааг 2023 оны 04 дүгээр сарын 03-ны өдрөөс 2 жилийн хугацаатай сунгасугай.

2. Тамхи худалдаалах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамж 100000 (нэг зуун мянга) төгрөгийг сумын орон нутгийн төсөвт төвлөрүүлэхийг Татварын улсын байцаагч (Н.Батсайхан)-д даалгасугай.

3. Тамхи худалдах тусгай зөвшөөрөл олгогдсон дэлгүүрийн үйл ажиллагаанд хяналт тавьж үр дүнг тооцон ажиллахыг Цагдаагийн тасгийн дарга, (Д.Энх-Амгалан цагдаагийн хошууч), татварын улсын байцаагч (Н.Батсайхан), Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, хоршоо хариуцсан мэргэжилтэн (Э.Бадамханд) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН